

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/033/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор С.Оргил
Утас: 77665858

Цахим хаяг: Info@shinjenmagadlakhui-audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 139
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨНДӨР-УЛААН
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б. БОЛОРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,669,575.3 мянган төгрөгийн санхүүжилт гүйцэтгэлээр 1,616,911.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын хүүхдийн цэцэрлэг нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 97 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	142,503,149.02	48,262,100.79
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	142,503,149.02	48,262,100.79
3121	Төгрөг	142,503,149.02	48,262,100.79
31211	Төрийн сангийн харилцах	142,503,149.02	48,262,100.79
33	АВЛАГА		2,829,309.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		2,829,309.00
35	БАРАА МАТЕРИАЛ	70,304,279.00	64,278,708.00
354	Хангамжийн материал	70,304,279.00	64,278,708.00
3542	Аж ахуйн материал	70,304,279.00	64,278,708.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	212,807,428.02	115,370,117.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	708,572,010.84	786,619,202.48
392	Биет хөрөнгө	688,631,810.84	766,890,002.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	573,303,673.12	696,401,841.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	-96,442,651.52	-115,948,389.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	113,376,102.70	118,341,671.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,219,635.22	-55,541,837.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,338,074.11	81,761,228.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,686,923.81	-42,779,956.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	130,271,233.87	132,671,233.87
39215	Хуримтлагдсан элэгдэл	-42,336,125.25	-54,153,853.41
39217	Ном	6,028,062.84	6,138,062.84
393	Биет бус хөрөнгө	19,940,200.00	19,729,200.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,589,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-825,000.00	-1,125,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,265,200.00	19,265,200.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	708,572,010.84	786,619,202.48
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	921,379,438.86	901,989,320.27
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		499,671.08
413	Өглөг		499,671.08
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		499,671.08
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		499,671.08
51	Засгийн газрын хувь оролцоо	921,379,438.86	901,489,649.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	955,034,746.80	955,034,746.80
51101	Өмч: - төрийн	955,034,746.80	955,034,746.80
512	Хуримтлагдсан үр дүн	-121,024,350.97	-140,914,140.64
5121	Өмнөх үеийн үр дүн	-121,024,350.97	-121,024,350.97
5122	Тайлант үеийн үр дүн		-19,889,789.67
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	87,369,043.03	87,369,043.03
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	921,379,438.86	901,489,649.19
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	921,379,438.86	901,989,320.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,270,527,300.00	1,522,670,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,208,068,300.00	1,335,305,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,208,068,300.00	1,335,305,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,459,000.00	187,365,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,459,000.00	187,365,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		45,595,875.00
120	Нийтлэг татварын бус орлого		45,595,875.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		16,799,775.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		28,796,100.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,270,527,300.00	1,568,266,775.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,347,652,148.56	1,588,156,564.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,328,060,015.72	1,575,990,969.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	932,550,695.67	1,115,068,799.18
210101	Үндсэн цалин	653,275,278.67	696,347,118.59
210102	Нэмэгдэл	207,479,618.00	348,084,688.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт		4,585,000.00
210104	Урамшуулал	71,795,799.00	66,051,992.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,059,296.12	133,004,976.13
210201	Тэтгэврийн даатгал	79,241,100.00	91,402,502.28
210202	Тэтгэмжийн даатгал	9,322,500.00	10,580,656.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,661,300.00	5,276,900.90
210204	Ажилгүйдлийн даатгал	4,661,300.00	5,069,701.57
210205	Эрүүл мэндийн даатгал	17,173,096.12	20,675,214.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,376,667.16	63,050,000.00
210301	Гэрэл, цахилгаан	14,024,267.16	12,550,359.34
210302	Түлш, халаалт	26,839,500.00	45,449,640.66
210303	Цэвэр, бохир ус	512,900.00	5,050,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,308,215.35	41,022,671.00
210401	Бичиг хэрэг	363,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		18,204,600.00
210408	Бараа материал акталсны зардал	22,945,215.35	22,818,071.00

2105	Нормативт зардал	101,733,650.00	116,077,960.00
210502	Хоол, хүнс	101,733,650.00	116,077,960.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,064,700.00	901,832.00
210604	Урсгал засвар	17,064,700.00	901,832.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,372,700.00	4,067,305.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,372,700.00	4,067,305.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,594,091.42	102,797,426.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,730,385.00	24,824,980.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,009,950.00	8,483,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,853,756.42	69,488,546.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,592,132.84	12,165,595.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,589,800.00	12,165,595.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,589,800.00	12,165,595.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,332.84	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,332.84	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,347,652,148.56	1,588,156,564.67
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-77,124,848.56	-19,889,789.67
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-77,124,848.56	-19,889,789.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,270,527,300.00	1,522,670,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,270,527,300.00	1,522,670,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,208,068,300.00	1,335,305,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,208,068,300.00	1,335,305,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,459,000.00	187,365,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,459,000.00	187,365,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,298,008,566.79	1,486,175,985.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,298,008,566.79	1,486,175,985.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,278,416,433.95	1,472,961,585.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	932,248,800.00	1,115,436,030.31
210101	Үндсэн цалин	617,338,460.00	696,831,999.59
210102	Нэмэгдэл	243,114,541.00	348,084,688.45

210103	Унаа хоолны хөнгөлөлт		4,467,350.00
210104	Урамшуулал	71,795,799.00	66,051,992.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,361,191.79	133,681,657.92
210201	Тэтгэврийн даатгал	79,241,100.00	91,402,502.28
210202	Тэтгэмжийн даатгал	9,322,500.00	10,580,656.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,661,300.00	5,277,499.66
210204	Ажилгүйдлийн даатгал	4,661,300.00	5,678,299.66
210205	Эрүүл мэндийн даатгал	17,474,991.79	20,742,699.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,220,167.16	63,050,000.00
210301	Гэрэл, цахилгаан	14,024,267.16	12,550,359.34
210302	Түлш, халаалт	26,839,500.00	45,449,640.66
210303	Цэвэр, бохир ус	1,356,400.00	5,050,000.00
2105	Нормативт зардал	101,733,650.00	116,077,960.00
210502	Хоол, хүнс	101,733,650.00	116,077,960.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,236,500.00	901,832.00
210604	Урсгал засвар	20,236,500.00	901,832.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,172,700.00	4,067,305.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,172,700.00	4,067,305.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,443,425.00	39,746,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,494,125.00	31,472,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,949,300.00	8,273,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,592,132.84	13,214,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,589,800.00	13,214,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,589,800.00	13,214,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,332.84	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,332.84	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-27,481,266.79	36,494,914.77
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		130,735,963.00
	Дотоод эх үүсвэрээр		130,735,963.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		130,735,963.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-130,735,963.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-27,481,266.79	-94,241,048.23
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		142,503,149.02
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		48,262,100.79

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	955,034,746.80	87,369,043.03	-121,024,350.97	921,379,438.86
19	Тайлант үеийн үр дүн			-19,889,789.67	-19,889,789.67
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	955,034,746.80	87,369,043.03	-140,914,140.64	901,489,649.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,537,135,000.00	1,522,670,900.00	14,464,100.00	99.06
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,350,085,000.00	1,335,305,900.00	14,779,100.00	98.91
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,350,085,000.00	1,335,305,900.00	14,779,100.00	98.91
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	187,050,000.00	187,365,000.00	-315,000.00	100.2
132001	Орон нутгийн төсвөөс	187,050,000.00	187,365,000.00	-315,000.00	100.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	132,440,300.00		132,440,300.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	132,440,300.00		132,440,300.00	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,669,575,300.00	1,522,670,900.00	146,904,400.00	91.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,669,575,300.00	1,616,911,948.23	52,663,351.77	96.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,656,360,900.00	1,603,697,548.23	52,663,351.77	96.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,150,901,500.00	1,115,436,030.31	35,465,469.69	96.92
210101	Үндсэн цалин	744,111,600.00	696,831,999.59	47,279,600.41	93.65
210102	Нэмэгдэл	355,239,600.00	348,084,688.45	7,154,911.55	97.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт		4,467,350.00	-4,467,350.00	
210104	Урамшуулал	51,550,300.00	66,051,992.27	-14,501,692.27	128.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,293,100.00	133,681,657.92	9,611,442.08	93.29
210201	Тэтгэврийн даатгал	97,213,900.00	91,402,502.28	5,811,397.72	94.02
210202	Тэтгэмжийн даатгал	11,519,800.00	10,580,656.80	939,143.20	91.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,759,900.00	5,277,499.66	482,400.34	91.62
210204	Ажилгүйдлийн даатгал	5,759,900.00	5,678,299.66	81,600.34	98.58

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл,
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	23,039,600.00	20,742,699.52	2,296,900.48	90.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,050,000.00	63,050,000.00		100
210301	Гэрэл, цахилгаан	18,000,000.00	12,550,359.34	5,449,640.66	69.72
210302	Түлш, халаалт	40,000,000.00	45,449,640.66	-5,449,640.66	113.6
210303	Цэвэр, бохир ус	5,050,000.00	5,050,000.00		100
2105	Нормативт зардал	123,664,300.00	116,077,960.00	7,586,340.00	93.87
210502	Хоол, хүнс	123,664,300.00	116,077,960.00	7,586,340.00	93.87
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	124,000,000.00	124,000,000.00		100
210604	Урсгал засвар	124,000,000.00	124,000,000.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,766,300.00	5,766,200.00	100	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,766,300.00	5,766,200.00	100	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,685,700.00	45,685,700.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,091,800.00	37,301,800.00	-210,000.00	100.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,593,900.00	8,383,900.00	210,000.00	97.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,214,400.00	13,214,400.00		100
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,214,400.00	13,214,400.00		100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,214,400.00	13,214,400.00		100
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,669,575,300.00	1,616,911,948.23	52,663,351.77	96.85
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		142,503,149.02	142,503,149.02	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		48,262,100.79	-48,262,100.79	
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43	43		
6	Удирдах ажилтан	2	2		100
7	Гүйцэтгэх ажилтан	32	32		100
8	Үйлчлэх ажилтан	9	9		100
15	Төрийн өмчит СӨБ байгууллага	230	230		100

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй, залруулаагүй 6,697.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн бөгөөд 6,697.1 мянган төгрөгт 3 албан шаардлага, 1 зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг зөрчил нь 6,697.1 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 17,866.76 мянган төгрөгөөс бага байгаа тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 2,486,168.62 төгрөгийн авлага үүссэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 -т 'эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр, дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах' гэсэн заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3.1.2. 2025 оны 03 сарын НДШ-ийн тайланд 1 иргэний цалин 1,991,400.00 төгрөгийг дутуу, 07 сарын НДШ-ийн тайланд 40 иргэний цалин 44,724,520.00 төгрөгийг илүү, 11 сарын НДШ-ийн тайланд 5 иргэний цалин 945,747.00 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1. "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" 14.4.4.-т "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр" 14.4.5-т "бүх орлого" заалтуудтай нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3.1.3. ХХОАТ-ын 1-р улирлын тайланг 1,038,587.5 төгрөгөөр тайлагнасан боловч Цалин хөлсний тооцооны хүснэгтэд 30,358,789.00 төгрөгөөр тайлагнасан нь 29,320,201.0 төгрөгөөр зөрүүтэй байна. ХХОАТ-ын 2-р улирлын тайланд 65,445,386.81 төгрөгөөр тайлагнасан боловч Цалин хөлсний тооцооны хүснэгтэд 67,681,305.0. төгрөгөөр тайлагнасан нь 2,235,518.00 төгрөгөөр зөрүүтэй байна. ХХОАТ-ын 3-р улирлын тайланд 83,387,598.71 төгрөгөөр тайлагнасан боловч Цалин хөлсний тооцооны хүснэгтэд 85,931,461.00 төгрөгөөр тайлагнасан нь 2,543,663.0 төгрөгөөр зөрүүтэй байна. ХХОАТ-ын 4-р улирлын тайланд 116,721,308.25 төгрөгөөр тайлагнасан боловч Цалин хөлсний тооцооны хүснэгтэд 120,950,161.00 төгрөгөөр тайлагнасан нь 4,228,853.0 төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.-т "Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дурдсан журмыг баримтална”, 25.1.1.энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх, 27.1.-т "Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1, 20.4-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлагатай холбоотой	1	2468.16	1		1	2468.16						
Цалин хөлстэй холбоотой	1	-	1		1	-						
Санхүүгийн тайлантай холбоотой	1	4228.9	1		1	4228.9						
Дүн	3	6,697.1	3		3	6,697.1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Архангай аймгийн Архангай аймгийн Өндөр улаан сумын хүүхдийн цэцэрлэг нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллээс 168 мэдээллийг хугацаанд байршуулж, 3 мэдээлэл хоцроон байршуулж ажилласан байна.	1	-			1	-
Дүн	1	-			1	-